



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

### “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Ю.Ганзоригтой байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Ю.Ганзоригтой Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Гүйцэтгэх захирал Ю.Ганзоригт хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Гүйцэтгэх захирал Ю.Ганзоригт хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий нягтлан бодогч Д.Мөнх-Оргилд зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001309

11-r huraldaan.docx



"АРХАНГАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛД 2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

/төгрөгөөр/

| д/д | Хуулийн этгээдийн нэр | Гүйцэтгэх захирлын нэр | Цэвэр ашиг    | Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал | Урамшуулал тооцох цэвэр ашиг | Олгох урамшууллын хэмжээ                                            |
|-----|-----------------------|------------------------|---------------|-----------------------------------------------------------------------------------|------------------------------|---------------------------------------------------------------------|
| 1   | "Архангай АЗЗА" ТӨХК  | Ю.Ганзориг             | 27,087,972.43 | -                                                                                 | 27,087,972.43                | 2,708,800.00 (Хоёр сая долоон зуун найман мянга найман зуун төгрөг) |